



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/99

Батноров сум

┌ Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянбулаг 4 дүгээр багийн нутаг Өвөр домбон "" гэх газарт нутаглаж байгаа малчин О.Төмөрбаатарын суурьт Галзуу өвчинтэй тэмцэх заавар, журмыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд өвчлөл илрээгүй тул 2024 оны 07 дүгээр сарын 09-ний өдөр хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.
2. Тухайн суурьт эцсийн халдваргүйтгэл хийж ажиллахыг Энхсүрэг вет эмнэлгийн малын их эмч (Г.Өсөхбаяр)-д үүрэг болгосугай.
3. Малын "Галзуу" өвчинтэй тэмцэх арга хэмжээний мэдээ тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д даалгасугай.
4. Хорио цээрийн дэглэмийг цуцалсантай холбогдуулан захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ган-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



Б.ЖАВХЛАНБАЯР